



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/145

Номгон

Аймгийн үндэсний спортын VII бага
наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/17 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн үндэсний спортын VII бага наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч : Ж.Мөнхсоёл (Аймгийн засаг даргын орлогч дарга)

Гишүүд: Б.Наранбаяр (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

С.Байгалмаа - (Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

Т.Эрдэнэбат - (Өлзийт сумын Засаг дарга)

Г.Нэмэхбаяр - (Цэргийн штабын дарга, хурандаа)

Ц.Дашцэрэн - (Үндэсний бөхийн холбооны тэргүүн)

Б.Мөнхбат - (Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга)

Ш.Батдаваа - (Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн дарга)

Ж.Хатанбаатар -(Хонгорын хурд морин спорт уяачдын холбооны нарийн бичгийн дарга)

С.Эрдэнэмөнх - (Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спорт хариуцсан мэргэжилтэн)

Т.Гомбо - (Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн)

Ж.Батболд - (Тэмүжин театрын дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Оюунбаатар -(Биеийн тамир, спортын газрын дарга)


2.Аймгийн Үндэсний спортын VII бага наадмын удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.

3.Тэмцээнд удирдамжийн дагуу баг тамирчдыг бэлтгэн оролцуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Мөнхсоёл) - д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 21-ний өдрийн А/145 дугаар
захирамжийн хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ҮНДЭСНИЙ СПОРТЫН
VII БАГА НААДМЫН НЭГДСЭН УДИРДАМЖ**

Нэг.Зорилго

Монголын үндэсний уламжлалт спортын төрлүүдийг хөгжүүлэх, хамгаалах, уламжлалт тоглоом наадгайн зан үйл, үндэсний ёс заншил, соёл, соёлын өвийг өсвөр залуу үеийнхэнд өвлүүлэх, сурталчлан таниулах, шигшээ тэмцээнд амжилттай оролцоход оршино.

Хоёр. Наадмын зохион байгуулалт хугацаа

Үндэсний спортын VII бага наадмыг аймгийн хэмжээнд спортын 6 төрлөөр 2020 оны 05 дугаар сарын 13-15-ний өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулж, Монголын Үндэсний спортын VII наадмын Шигшээ тэмцээнд оролцох баг, тамирчдыг сонгон шалгаруулах.

Гурав. Зохион байгуулагдах журам

Аймгийн Үндэсний спортын VII бага наадамд оролцох баг тамирчид мэдүүлгийг доорх маягтын дагуу бөглөж ирүүлнэ.

Маягтын дагуу мэдүүлгийг ирүүлээгүй баг тамирчдын наадамд оролцуулахгүй болно.

Техникийн зөвлөгөөн 2022 оны 05 дугаар сарын 12-ний 15:00 цагт Биеийн тамир спортын газрын хурлын танхимд болно.

Аймгийн үндэсний спортын VII бага наадамд сумуудаас оролцох баг тамирчдын тоо

д/д	Спортын төрөл	Оролцогчдын тоо	Зохион байгуулагдах газар	Мэдээлэл авах утас
1	Үндэсний бөх	Улсын цолтой -1, аймгийн цолтой-1, сумын цолтой-1 цолгүй бөх-1 нийт-4 бөх нэг баг болж оролцоно.	БТСГазар	88833082
2	Үндэсний сурын харваа	Багийн харваа-15 хүн Цуваа харваа-1 эрэгтэй, 1 эмэгтэй, Зэв нүүлгэх-1 эрэгтэй, 1 эмэгтэй	Аймгийн Үндэсний сурын талбайд	89303797
3	Үндэсний шагайн харваа	Багийн харваа-8 гишүүнтэй	БТСГазар	88809933
4	Ширээний шагай	Ганцаарчилсан: эрэгтэй-1, эмэгтэй-1, охид-1 хөвгүүд-1 \16 хүртэлх насны\ Багийн тоглолт: 4 хүн	БТСГазар	89113813

5	Уран уургач, бугуйлч, эмнэг булгиулагч	Уран уургач-1, эмнэг булгиулагч-1, бугуйлч-1,	Өлзийт сумын нутаг Өргөн ширэгт 2022 оны 05 дугаар сарын.....өдөр	89113813
6	Уламжлалт сурын харваа	Багийн харваа: 8 хүн, Эрэгтэй-5, эмэгтэй-3, Цуваа харваа: Эрэгтэй-1, эмэгтэй-1,	Аймгийн Үндэсний сурын талбайд	89303797

Дөрөв. Дүгнэх журам, шагнал урамшуулал

Үндэсний спортын VII бага наадмын спортын төрөл тус бүрд эхний 3 байрт шалгарсан баг тамирчдыг Өргөмжлөл, медаль, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Байгууллагын нэгдсэн дүнгээр эхний 3 байрт шалгарсан Сумуудыг өргөмжлөл, дурсгалын цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

_____оОо_____